



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН
УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ

2023 оны 12 сарын 28 өдөр

Дугаар 14

Улаанбаатар хот

Г Дүрэмд өөрчлөлт оруулах тухай Г

Монгол Улсын Боловсролын ерөнхий хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсэг, Дээд боловсролын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.1 дэх заалт, МУИС-ийн Удирдах зөвлөлийн дүрмийн 3.4 дэх хэсэг, МУИС-ийн Удирдах зөвлөлийн 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн хурлын тэмдэглэл, шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

- “Монгол Улсын Их Сургуулийн Дүрэм”-д өөрчлөлт оруулан хавсралтаар баталсугай.
- Батлагдсан дүрмийг 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг МУИС-ийн ректор (Д.Бадарч)-т үүрэг болгосугай.
- Дүрмийг өөрчлөн баталсантай холбогдуулан МУИС-ийн Удирдах зөвлөлийн 2023 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн 13 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.


ДАРГА

М.БАТГЭРЭЛ



1423010020

МУИС-ийн Удирдах зөвлөлийн 2023 оны 12 дугаар
сарын 28-ны өдрийн ... дугаар тогтоолын хавсралт



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН ДҮРЭМ

НЭГ. Нийтлэг үндэслэл

- 1.1. Монгол Улсын Их Сургуулийн үндсэн үйл ажиллагааг бүтээмжтэй, үр нөлөөтэй, ил тод, хууль ёсны дагуу хэрэгжүүлэх, удирдлагын тогтолцоо, зохион байгуулалт, үндсэн үйл ажиллагаанд оролцогчдын эрх зүйн байдал, сургалт, судалгаа, санхүүжилттэй холбогдох хуулиар тусгайлан зохицуулаагүй харилцааг зохицуулахад энэхүү дүрмийн зорилго оршино.
- 1.2. Энэхүү дүрэм нь их сургуулийн хэмжээнд мөрдөгдөж байгаа эрх зүйн баримт бичгийн үндэс болох бөгөөд бусад дүрэм, журам энэхүү дүрэмтэй нийцсэн байна.
- 1.3. Монгол Улсын Их Сургууль нь хамтын болон өөрийн удирдлагатай, нийтийн өмчид суурилсан судалгааны их сургууль бөгөөд бие даасан хуулийн этгээд мөн.
- 1.4. Монгол Улсын Их Сургуулийн төв удирдлага Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотод байрлана. Албан ёсны хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, 14201, Их сургуулийн гудамж-1, Байгууллагын товчилсон нэр: МУИС; англи орчуулга: National University of Mongolia, орчуулгын товчлол: NUM; цахим хуудас: <https://www.num.edu.mn> болно.
- 1.5. МУИС тогтоосон журмын дагуу үйлдэж, оюуны өмчийн эрхийг баталгаажуулсан албан бичгийн хэвлэл хуудас, тэмдэг, бэлгэдэл (түг, лого, уриа)-тэй байна. МУИС-ийн уриа: “Эрдмийн хэт цахиваас Хөгжлийн гал бадармуй” “Эрдмийн хэт цахиваас Хөгжлийн гал бадармуй”.
- 1.6. МУИС үйл ажиллагаагаа олон нийтэд шуурхай мэдээлэх, сурталчлах зорилгоор фейсбууқ, твиттер, инстаграм г.м. олон нийтийн мэдээллийн сүлжээг ашиглаж болно.
- 1.7. МУИС-ийн үйл ажиллагаанд дараах үндсэн зарчмыг баримтална.
 - 1.7.1. Хууль дээдлэх;
 - 1.7.2. Хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх;
 - 1.7.3. Эрдмийн эрх чөлөөг эрхэмлэх;
 - 1.7.4. Бие даасан байдлыг хангах;
 - 1.7.5. Хариуцлагатай, ёс зүйтэй байх;
 - 1.7.6. Шударга ёсыг сахих.

ХОЁР. МУИС-ийн үндсэн чиг үүрэг

- 2.1. Шинжлэх ухааны суурь ба хэрэглээний чиглэлүүдээр судалгаа хийх, шинэ мэдлэг бүтээж өдийн засгийн ба оюуны эргэлтэд оруулах, сургалт, үйлдвэрлэлд нэвтрүүлэх;
- 2.2. Шинжлэх ухаан, технологийн ололт, сургалтын нийтлэг шаардлагад нийцсэн, улс орныхоо өдийн засаг, соёл, нийгмийн хөгжилд чухал шаардлагатай мэргэжлээр бакалавр, магистр, докторын зэрэг олгох сургалт эрхэлж, мэргэжлийн болон иргэний өндөр боловсролтой мэргэжилтэн бэлтгэх, үндэсний мэргэжилтнийг чадавхжуулах, насан туршийн боловсрол олгох;

- 2.3. Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд чиглэсэн бодлого **боловсруулах**, шийдвэр гаргахад шаардлагатай шинжлэх ухааны үндэслэлтэй санал зөвлөмж боловсруулж дэвшүүлэх; нийгмийг соён гэгээрүүлэх, эрдэм мэдлэг түгээх;
- 2.4. Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах, үндэсний уламжлал, түүх, хэл, соёлын дархлааг бэхжүүлэх, монгол судлалыг хөгжүүлэх, олон улсын мэдлэгийн санд хувь нэмэр оруулах судалгааг хөгжүүлэх;
- 2.5. Багш, ажилтан, суралцагчдын ажиллах, суралцах тааламжтай нөхцөлийг бүрдүүлэх, эрхийг хамгаалах, хөгжүүлэх, нийгмийн асуудлыг **шийдвэрлэх** бодлого хэрэгжүүлэх.

ГУРАВ. МУИС-ийн үйл ажиллагаа

- 3.1. Бие даасан засаглалтай байх ба эрдэм шинжилгээ, сургалт, нийгмийг соён гэгээрүүлэх үндсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэх;
- 3.2. Хөгжлийн бодлогоо судалгааны их сургуулийн чиг баримжаагаар боловсруулж хэрэгжүүлэх; орчин үеийн хөгжлийн чиг хандлага, шаардлагад нийцүүлэн хөгжлийн стратеги боловсруулж, санхүүжилтийг баталж хэрэгжүүлэх. Стратегийн төлөвлөгөөний биелэлтийг үе шат бүрээр үнэлж дүгнэх;
- 3.3. Үндсэн үйл ажиллагаагаа хичээлийн жилээр төлөвлөн хэрэгжүүлж, биелэлтийг үнэлэх;
- 3.4. Эрдэм шинжилгээ, сургалт, нийгэмд чиглэсэн үйл ажиллагаа болон багш, ажилтан, суралцагчийн харилцааг холбогдох дүрэм, журмаар зохицуулах;
- 3.5. Багш, ажилтан, суралцагчдад үзүүлэх нийтлэг үйлчилгээг цахим болгох, захиргааны болон сургалт, судалгааны өгөгдлийн сан бүрдүүлж, мэдээллийг онлайн хэлбэрт шилжүүлж, тогтмол шинэчлэх, мэдээллийн хүртээмж, ил тод байдлыг хангаж ажиллах.

ДӨРӨВ. МУИС-ийн бүтэц

- 4.1. МУИС нь хэвийн, тогтвортой үйл ажиллагаа явуулах нөхцөлийг хангасан зохион байгуулалт, бүтэцтэй буюу сургалт, судалгааны нэгж (бүрэлдэхүүн, салбар, ахисан түвшний сургууль, тэнхим, хүрээлэн, төв, лаборатори, шинжлэх ухааны парк, ахлах сургууль)-тэй байна. Бүрэлдэхүүн сургууль салбарын бүтэцтэй байж болно.
- 4.2. Нийслэлээс бусад засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид байрлах салбар сургууль нь МУИС-ийн үндсэн чиг үүргийн дагуу үйл ажиллагаа эрхлэх бөгөөд орон нутгийн онцлогоос хамаарсан сургалт, судалгааны ажлыг хэрэгжүүлж болно.
- 4.3. МУИС нь үндсэн үйл ажиллагааны хэрэгжилтийг дэмжих чиг үүрэг бүхий захиргаа, үйлчилгээний нэгжүүдтэй байна. Үйлчилгээний зарим нэгжийн ажил үүргийг гаднын байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлж болно.
- 4.4. Багш, ажилтан, суралцагчдад үзүүлдэг нийтлэг үйлчилгээг цахим болгохтой холбогдуулан захиргаа, үйлчилгээний нэгжүүдийн бүтцийг цомхон байлгах, зохистой харьцааг баримтална.
- 4.5. МУИС-ийн сургалт, судалгааны нэгжийг байгуулах, өөрчлөн байгуулахтай холбоотой асуудлыг дор дурдсанаар шийдвэрлэнэ.
- 4.5.1. МУИС-ийн салбар, харьяа байгууллагыг байгуулах, өөрчлөх, татан буулгах асуудлыг Засгийн газар шийдвэрлэнэ.
- 4.5.2. МУИС-ийн захиргааны бүтэц, бүрэлдэхүүний сургууль, тэнхимийг байгуулах, өөрчлөх, татан буулгах асуудлыг МУИС-ийн Удирдах зөвлөл шийдвэрлэнэ.

- 4.5.3. Энэхүү дүрмийн 4.5.1, 4.5.2-д зааснаас бусад МУИС-ийн нэгжийг байгуулах, өөрчлөх, татан буулгах асуудлыг тусгай журмаар зохицуулж, ректорын тушаалаар баталгаажуулна.
- 4.6. МУИС-ийн бүрэлдэхүүн, салбар сургууль батлагдсан төсвийн хүрээнд үйл ажиллагаа явуулж, ажлын чанар, үр дүнг ректорт танилцуулж дүгнүүлнэ.

ТАВ. МУИС-ийн удирдлага



- 5.1. Удирдлагын тогтолцоо
- 5.1.1. МУИС хуульд заасны дагуу Удирдах зөвлөл, Эрдмийн зөвлөл, гүйцэтгэх удирдлагаас бүрдсэн удирдлагын тогтолцоотой байна.
- 5.1.2. Шийдвэр гаргах субъект бүр хууль болон энэ дүрмээр тодорхойлсон эрх, үүрэгтэй байна.
- 5.1.3. Удирдах зөвлөл, Эрдмийн зөвлөл нь бодлого тодорхойлж, нийтлэг дүрэм журмыг батална. Гүйцэтгэх удирдлага их сургуулийн өдөр тутмын үйл ажиллагаатай холбоотой шийдвэр гаргана.
- 5.2. Удирдах зөвлөл
- 5.2.1. Хуульд заасны дагуу МУИС нь үүсгэн байгуулагч, багш, суралцагч, төгсөгч, ажил олгогчийн төлөөллөөс бүрдсэн Удирдах зөвлөлтэй байна.
- 5.2.2. Удирдах зөвлөл боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан нийтлэг дүрэм болон өөрийн баталсан дүрмийг баримталж ажиллана.
- 5.2.3. МУИС-ийн Удирдах зөвлөл нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:
- 5.2.3.1. МУИС-ийн хөгжлийн бодлого, стратеги төлөвлөгөөг хэлэлцэн батлах, өөрчлөх;
- 5.2.3.2. МУИС-ийн дүрэм, түүний нэмэлт, өөрчлөлт, бүтэц, зохион байгуулалтыг хэлэлцэж батлах;
- 5.2.3.3. МУИС-ийн жилийн төсөв, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталж, гүйцэтгэл, зарцуулалтад хяналт тавих;
- 5.2.3.4. Аж ахуйн нэгж байгууллага, иргэдээс хандив тусламж авах журам тогтоо, зарцуулалтад хяналт тавих;
- 5.2.3.5. Сургалтын болон оюутны байрны төлбөр, оюутны үйлчилгээний зардлын хэмжээг тогтоох;
- 5.2.3.6. МУИС-ийн үйл ажиллагааны тайланг хэлэлцэн үнэлж дүгнэлт гаргах;
- 5.2.3.7. Сонгон шалгаруулалтын дүнг үндэслэн ректорыг томилох, гэрээ байгуулах, ажлыг нь үнэлэх, гэрээг дүгнэх, чөлөөлөх.
- 5.2.4. Удирдах зөвлөлийн үйл ажиллагааны зардлыг МУИС-ийн жилийн төсөвт тусган санхүүжүүлнэ.
- 5.2.5. Удирдах зөвлөлийн үйл ажиллагааг дүрмээр зохицуулна.
- 5.2.6. МУИС-ийн санхүүгийн бодлого, стратеги төлөвлөгөөний хэрэгжилт, төсвийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад хяналт тавих үүрэг бүхий орон тооны дотоод аудиторыг Удирдах зөвлөлөөс томилж ажиллуулна.
- 5.3. Эрдмийн зөвлөл
- 5.3.1. МУИС нь эрдмийн зэрэг, цолтой багш нарын төлөөллөөс бүрдсэн Эрдмийн зөвлөлтэй байна. Эрдмийн зөвлөл нь эрдэм шинжилгээ, сургалт, багш, оюутны хөгжлийн талаар хэрэгжүүлэх бодлогыг тогтоож, түүний хэрэгжилт, үр дүнг хэлэлцэж санал, дүгнэлт, зөвлөмж гаргана. Эрдмийн зөвлөлийн үйл ажиллагааг журмаар зохицуулна.
- 5.3.2. Эрдмийн зөвлөл 21-ээс доошгүй, 71-ээс дээшгүй гишүүнтэй байна. Эрдмийн зөвлөлийн гишүүдийн 60 хүртэлх хувь нь профессор, 40 хүртэлх хувь нь дэд профессорын төлөөллөөс бүрдэнэ.

- 5.3.3. Эрдмийн зөвлөлд сонгох гишүүний тоог бүрэлдэхүүн, салбар сургуульд үндсэн орон тоогоор ажиллаж буй эрдмийн зэрэг, цолтой багшийн тоонд ногдуулж тогтооно.
- 5.3.4. МУИС-ийн ректор, проректорууд, Эрдмийн зөвлөлийн гишүүн байна.
- 5.3.5. Эрдмийн зөвлөлийн сонгуулийг 3 жил тутамд явуулна.
- 5.3.6. Эрдмийн зөвлөл нь дарга, нарийн бичгийн даргатай байна. Эрдмийн зөвлөлийн дарга нь МУИС-ийн ректор байна.
- 5.3.7. Эрдмийн зөвлөлийн үйл ажиллагааны зардлыг МУИС-ийн жилийн тасварт тусган санхүүжүүлнэ.
9023041184
3150041184101
- 5.3.8. Эрдмийн зөвлөл дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:
- 5.3.8.1. МУИС-ийн хөгжлийн хөтөлбөр, эрдэм шинжилгээ, сургалт, хөтөлбөрийн бодлогыг тодорхойлж, судалгааны төсөл, хөтөлбөр, ахисан түвшний сургалт, судалгааны үр дүнг хэлэлцэж санал, дүгнэлт гаргах;
- 5.3.8.2. МУИС-ийн дүрэм, түүнд оруулах нэмэлт өөрчлөлтийг хэлэлцэн саналаа Удирдах зөвлөлд хүргүүлэх;
- 5.3.8.3. МУИС-ийн сургалт, судалгааны бодлого, үйл ажиллагаатай холбоотой нийтлэг журмыг хэлэлцэж батлах;
- 5.3.8.4. Боловсролын зэрэг олгох сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг хэлэлцэх, дүгнэлт гаргах;
- 5.3.8.5. МУИС-ийн хичээлийн жилийн тайланг хэлэлцэх;
- 5.3.8.6. МУИС-ийн эрдмийн цол, хүндэтгэл олгох;
- 5.3.8.7. МУИС-ийн ректорын үйл ажиллагааны талаар саналаа удирдах зөвлөлд оруулах.

5.4. Ректор

- 5.4.1. Ректор нь МУИС-ийг төлөөлж, өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.
- 5.4.2. Ректорын албан тушаалд тавих шаардлагыг Боловсролын тухай хууль тогтоомжийн холбогдох заалтын дагуу боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан ажлын байрны тодорхойлолтоор тогтооно.
- 5.4.3. Ректор их сургуулийн удирдлагыг Монгол Улсын хууль тогтоомж, энэхүү дүрэм, Удирдах зөвлөлтэй байгуулсан гэрээний дагуу хэрэгжүүлнэ.
- 5.4.4. Ректор ажлын байрны тодорхойлолт, албан тушаалд тавигдах шаардлагыг үндэслэн үйл ажиллагааны үндсэн чиглэлээр проректор, ажлын албаны даргыг болзол хангасан МУИС-ийн багш нараас сонгон, судлан шалгаруулалтын дүнг үндэслэн томилно.
- 5.4.5. Ректорыг эзгүй байх хугацаанд албан үүргийг нь аль нэг проректор эсвэл ректорын ажлын албаны дарга түр орлон гүйцэтгэнэ. Түр орлосон этгээдийн гаргасан шийдвэрийн хариуцлагыг ректор хүлээнэ.
- 5.4.6. МУИС нь үйл ажиллагааны чиглэлээр бодлогын газар, үйлчилгээний төвүүдтэй байх ба тэдгээр нэгжийн орон тоо, удирдлагыг холбогдох проректорын саналыг үндэслэн ректор батална. Бодлогын газар, төвүүдийн удирдлагатай үр дүнгийн гэрээ байгуулж, биелэлтийг дүгнэж ажилана.
- 5.4.7. Ректорт бүрэн эрхээ хэрэгжүүлэх, шийдвэр гаргах, захиргааны шуурхай удирдлагыг хангахад дэмжлэг үзүүлэх үүрэгтэй ажлын алба, ректорын зөвлөл ажиллана. Ректорын зөвлөлд асуудал эрхэлсэн проректор, ажлын албаны дарга, ректорын шууд харьяаны бодлогын газрын дарга, бүрэлдэхүүн, салбар сургуулийн захирал орно.
- 5.4.8. Ректор дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

- 5.4.8.1. Дээд боловсрол, шинжлэх ухаан, технологийн талаарх төрийн бодлогод нийцүүлэн сургуулийн хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулан Удирдах зөвлөлөөр батлуулж, хэрэгжүүлэх, тайлагнах;
- 5.4.8.2. Хууль тогтоомжийн дагуу МУИС-ийн дүрэм, түүнд холбогдох өөрчлөлт, бүтэц, зохион байгуулалтыг тогтоох, өөрчлөх, татан буулгах саналаа Удирдах зөвлөлд тавьж шийдвэрлүүлэх;
- 5.4.8.3. Бүрэлдэхүүн, салбар сургууль, харьяа нэгжийн удирдлагын ажлын тайланг сонсож, үйл ажиллагаанд нь үнэлэлт, дүгнэлт өгөх;
- 5.4.8.4. МУИС-ийн харьяа нэгжийн удирдах албан тушаалтныг томилох, чөлөөлөх;
- 5.4.8.5. Холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн МУИС-д мөрдөх дүрэм, журмыг боловсруулах, батлах, мөрдүүлэх;
- 5.4.8.6. Багш, ажилтны ажлын байрны тодорхойлолтыг батлах, ажилд томилох, хөдөлмөрийн гэрээ байгуулах, биелэлтийг дүгнэх, цуцлах;
- 5.4.8.7. Сургуулийг хөгжүүлэх хөрөнгө, хандив, сургуулийн санхүү, хөрөнгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх;
- 5.4.8.8. МУИС-ийн гадаад харилцааны бодлогыг тодорхойлж, бусад орны их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагатай харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэх;
- 5.4.8.9. Суралцагч элсүүлэх, шилжүүлэн суралцуулах, чөлөөлөх, төгсгөх асуудлыг зохих журмын дагуу шийдвэрлэх.

5.5. Бүрэлдэхүүн, салбар сургуулийн удирдлага

5.5.1. Бүрэлдэхүүн, салбар сургууль эрдмийн зөвлөлтэй байна.

5.5.1.1. Бүрэлдэхүүн, салбар сургуулийн эрдмийн зөвлөл нь тухайн сургуулийн профессор, дэд профессорын зэрэглэлд ажиллаж буй багш нарын 40 хүртэл хувийн төлөөллөөс бурдэнэ. Эрдмийн зөвлөлийн гишүүдийн 60 хүртэлх хувь нь профессор, 40 хүртэлх хувь нь дэд профессор байна.

5.5.1.2. Бүтцийн онцлогоос хамааруулан бүрэлдэхүүн, салбар сургуулийн эрдмийн зөвлөлд сонгох багшийн төлөөллийг нэмэгдүүлж болох ба өөр сургуулийн төлөөллийг эрдмийн зөвлөлийн гишүүнээр сонгон ажиллуулж болно.

5.5.1.3. Эрдмийн зөвлөлийн гишүүнийг тухайн сургуулийн докторын зэрэгтэй үндсэн орон тооны багш нарын гуравны хоёроос доошгүй ирцтэй хурлаас нууц санал хураалтаар сонгоно.

5.5.1.4. Бүрэлдэхүүн, салбар сургуулийн захирал эрдмийн зөвлөлийн дарга байна. Эрдмийн зөвлөлийн гишүүдээс нарийн бичгийн даргыг сонгоно.

5.5.1.5. Бүрэлдэхүүн, салбар сургуулийн эрдмийн зөвлөл нь МУИС-ийн эрдмийн зөвлөлийн үйл ажиллагааны журмыг мөрдлөг болгоно.

5.5.2. Бүрэлдэхүүн, салбар сургуулийн эрдмийн зөвлөл дараах чиг үүрэгтэй.

5.5.2.1. Бүрэлдэхүүн, салбар сургуулийн сургалт, судалгааны бодлогыг тодорхойлох, санал дэвшүүлэх;

5.5.2.2. Бүрэлдэхүүн, салбар сургуулийн хүндэт цол олгох асуудлаар шийдвэр гаргах;

5.5.2.3. Тухайн сургуулийн эрдэмтдийн боловсруулан дэвшүүлсэн эрдэм шинжилгээний төсөл, хөтөлбөр, гэрээт судалгааны ажлын талаар дүгнэлт гаргах, хэрэгжүүлсэн төслийн явцын ба эцсийн тайланг хэлэлцэж үнэлэлт дүгнэлт өгөх;

- 5.5.2.4. Багш нарт бүтээлийн чөлөө олгох асуудлыг хэлэлцэж шийдвэрлэх, үр дүнг хэлэлцэж дүгнэлт гаргах;
- 5.5.2.5. Бүрэлдэхүүн, салбар сургуулийн захирлын үйл ажиллагааны талаар саналаа МУИС-ийн ректорт гаргах.
- 5.5.3. Бүрэлдэхүүн, салбар сургуулийн өдөр тутмын үйл ажиллагааг захирал удирдана.
- 5.5.3.1. Бүрэлдэхүүн, салбар сургуулийн захирал нь докторын зэрэгтэй, МУИС-д 10-аас доошгүй жил ажилласан байх ба уүний 3-аас доошгүй жил удирдах албан тушаалд ажилласан байна.
- 5.5.3.2. Бүрэлдэхүүн сургуулийн захирлыг судлан шалгаруулах ажлын хэсгийг МУИС-ийн ректорын тушаалаар байгуулна. Ажлын хэсэг шаардлага хангасан нэр дэвшигчдийг тодруулж, үндсэн орон тооны багш болон зөвлөх профессор, зөвлөх дэд профессор нарын 50-аас дээш хувийн ирцтэй хурлаар нууц санал хураалт явуулж, хамгийн олон санал авсан 2 нэр дэвшигчээс МУИС-ийн ректор сонгон томилно.
- 5.5.3.3. Бүрэлдэхүүн сургуулийн захирлыг 3 жилийн хугацаагаар томилно. Захирал бүрэн эрхийн хугацаа дуусахаас 1 сарын өмнө ажлын тайлангаа үндсэн орон тооны багш болон зөвлөх профессор, зөвлөх дэд профессор нарын хуралд хэлэлцүүлнэ. Захирлын ажлыг нууц санал хураалтаар үнэлнэ. Захирлын ажлыг олонх нь хангалттай гэж үзвэл 1 удаа үргэлжлүүлэн ажиллуулах үндэслэл болно.
- 5.5.3.4. Захирал эрх, үүргээ хэрэгжүүлэх, шийдвэр гаргах, захиргааны шуурхай удирдлагыг хангахад дэмжлэг үзүүлэх үүрэгтэй бүрэлдэхүүн, салбар сургуулийн захиргааны зөвлөлийг ажиллуулна.
- 5.5.4. Бүрэлдэхүүн, салбар сургуулийн захирал дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.
- 5.5.4.1. МУИС-ийн нэгдсэн бодлого, стратеги төлөвлөгөөний дагуу бүрэлдэхүүн, салбар сургуулийг хөгжүүлэх бодлого, хөтөлбөр боловсруулах, мөрдөж ажиллах, хэрэгжилтийг хангах, сургуулийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах;
- 5.5.4.2. Бүрэлдэхүүн, салбар сургуулийн хэмжээнд сургалтын үйл ажиллагааг өдөр тутмын удирдлагаар хангаж, шаталсан сургалтын хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх, гүйцэтгэлд хяналт тавих, хөтөлбөрийг магадлан итгэмжлүүлэх, магистрант, докторантыг сургалт, судалгааны туслахаар ажиллуулах асуудлыг зохион байгуулах;
- 5.5.4.3. Бүрэлдэхүүн, салбар сургуулийн судалгааны бодлого боловсруулах, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, төсөл, хөтөлбөрийн тоо, чанарыг сайжруулах, судалгаа, шинжилгээний ажлын үр дүнг эдийн засгийн эргэлтэд оруулах, олон нийтэд сурталчлах, сургалт-судалгааны ажлын нэгдлийг хангах;
- 5.5.4.4. МУИС-ийн ректороос шилжүүлсэн эрхийн хүрээнд бүрэлдэхүүн, салбар сургуулийн санхүүгийн удирдлагыг хэрэгжүүлж, батлагдсан төсвийг захираан зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах, ил тод мэдээлэх, олон эх үүсвэрт санхүүгийн тогтолцоог бий болгох, сургуулийн санхүүгийн чадавх, материаллаг баазыг бэхжүүлэх, багш, ажилтан, суралцагчдын ажиллах, суралцах таатай орчин нөхцөлийг хангах;

- 5.5.4.5. МУИС-ийн ректороос шилжүүлсэн эрхийн хүрээнд бүрэлдэхүүн, салбар сургуулийн суралцагчтай холбоотой /сургалтын тэрээ байгуулах, жилийн чөлөө олгох, үргэлжлүүлэн суралцуулах/ асуудлыг шийдвэрлэх, багш, ажилтантай хөдөлмөрийн гэрээ байгуулах, гэрээг цуцлах, чөлөө олгох, үргэлжлүүлэн ажиллуулах саналыг МУИС-ийн захиргаанд уламжлах;
- 5.5.4.6. Бүрэлдэхүүн, салбар сургуулийг төлөөлж гадаад, дотоодын их, дээд сургууль, байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулах, хамтын ажиллагааг хөгжүүлэх, харилцаан туршлага солилцох ажлыг зохион байгуулах;
- 5.5.4.7. Тэнхим, лаборатори, төвийн үйл ажиллагааг үнэлж, дүгнэх, тэдгээрийн удирдлагыг өөрчлөх асуудлаар МУИС-ийн ректорт санал оруулах;
- 5.5.4.8. Сургууль нийгмийн харилцаа холбоог хөгжүүлэх, төгсөгчдийг ажлын байраар хангах, мэргэжил дээшлүүлэх, төгсөгчдийг дэмжиж, хамтран ажиллах;
- 5.5.4.9. Хичээлийн жил бүр ажлын төлөвлөгөө боловсруулан мөрдөж, биөлэлтийг хамт олны хуралд тайлагнах;
- 5.5.4.10. Бүрэлдэхүүн, салбар сургуулийн багш, ажилтныг хөгжүүлэх, мэдлэг боловсролыг нь дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх.
- 5.6. Тэнхимиийн эрхлэгч
- 5.6.1. Тэнхимиийн эрхлэгч нь тухайн салбараар мэргэшсэн, их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагад 6-аас доошгүй жил ажилласан, профессор, дэд профессорын зэрэглэлд 3-аас доошгүй жил ажилласан байна.
- 5.6.2. Тэнхимиийн эрхлэгчийг тэнхимиийн үндсэн орон тоон дээр ажиллаж буй багш нарын 50-аас дээш хувийн ирцтэй хурлаар нууц санал хураалт явуулж, хамгийн олон санал авсан 2 нэр дэвшигчээс МУИС-ийн ректор сонгон томилно.
- 5.6.3. Тэнхимиийн эрхлэгчийг 2 жилийн хугацаагаар томилно. Эрхлэгч бүрэн эрхийн хугацаа дуусахаас 1 сарын өмнө ажлын тайлангаа тэнхимиийн үндсэн орон тооны багш нарын хуралд хэлэлцүүлнэ. Эрхлэгчийн ажлыг нууц санал хураалтаар үнэлэх ба олонх нь хангалттай гэж үзвэл 1 удаа үргэлжлүүлэн ажиллуулж болно. Тэнхимиийн эрхлэгч дурдсан хугацаанд тайлангаа хэлэлцүүлэгүй бол энэ нь түүнийг албан тушаалаас чөлөөлөх үндэслэл болно.
- 5.6.4. Тэнхимиийн шийдвэр гаргах хэлбэр нь тэнхимиийн хурал байна. Багш нарын гуравны хоёроос доошгүй ирцтэй хурлаас олонхын саналаар шийдвэр гаргана.
- 5.6.5. Тэнхимиийн эрхлэгч дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.
- 5.6.5.1. Тэнхимиийн сургалт, судалгааны үйл ажиллагааг үр ашигтай, хариуцлагатай удирдан зохион байгуулах;
- 5.6.5.2. Мэргэжил, хөтөлбөрөө сурталчлах, гадаад харилцаа хамтын ажиллагааг хөгжүүлэх;
- 5.6.5.3. Тэнхимиийн багш, ажилтны мэргэжлийн үйл ажиллагаа, ёс зүйн байдалд дүгнэлт өгөх, зөрчил гаргасан тохиолдолд хариуцлага тооцох талаар дээд шатны удирдлагад санал оруулах;
- 5.6.5.4. Тэнхимиийн багш, ажилтныг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, үйл ажиллагаанд жигд оролцох боломжийг хангах;
- 5.6.5.5. Тэнхимиийн сургалт, судалгааны үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийх, дүгнэлт гаргуулах, үр дүнг тэнхимиийн хурлаар хэлэлцүүлэх;

- 5.6.5.6. Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах үүднээс тэнхимийн хичээлийн хуваарь, оюутны сонголтод үндэслэн багш, анги танхимиын хүрэлцээ, сургалтын техник тоог төхөөрөмжийн хангамж, хэвийн ажиллагаанд хяналт тавьж ажиллах;
- 5.6.5.7. Тэнхимийн харьяаллын ерөнхий суурь, үндсэн мэргэжил, хавсарга мэргэжил, хос мэргэжлийн хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллах, хичээлийн болон цагийн ноогдлын хуваарилалтыг оновчтой хийх, оюутан ⁸⁶²²⁰⁴¹¹⁶⁴ ~~910431~~ суралцагчдыг шаардлагатай мэдээллээр хангах;
- 5.6.5.8. Хичээлийн жил бүр ажлын төлөвлөгөө боловсруулан мөрдөж, биелэлтийг хичээлийн жилийн төгсгөлд тэнхимийн хамт олны хуралд тайлагнах.

ЗУРГАА. Хөтөлбөрийн хороо

- 6.1. Сургалтын хөтөлбөрийн талаарх бодлогыг хэрэгжүүлэх, сургалтын хөтөлбөрийг боловсруулах, батлах, үнэлэх үүрэг бүхий Хөтөлбөрийн хороо тэнхим, бүрэлдэхүүн, салбар сургууль, МУИС-ийн түвшинд ажиллана.
- 6.2. Хөтөлбөрийн хороо нь бүх түвшний сургалтын хөтөлбөрийг боловсруулах, хэлэлцэж батлах, шинэчлэх, шаталсан сургалтын уялдаа холбоог хангах, ерөнхий суурь, мэргэжлийн суурь болон мэргэжлийн хичээлүүдэд тавигдах шаардлага, багц цагийг тогтоох, тэдгээрийг шилжүүлэх нөхцөлийг тодорхойлох, хөтөлбөрийн чанарын шаардлагад үнэлгээ хийх зэрэг хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлаар хэлэлцэж шийдвэр гаргана.
- 6.3. Хөтөлбөрийн хорооны үйл ажиллагааг журмаар зохицуулна. Хөтөлбөрийн хороо ажлаа Эрдмийн зөвлөлд тайлагнана.

ДОЛОО. МУИС-ийн багш, ажилтан

- 7.1. МУИС-ийн багш, ажилтан яс үндэс, уг гарал, шашин шүтлэг, нас, хүйс, улс төрийн үзэл бодол, гэр бүлийн байдал зэрэг ямар нэгэн ялгavarлан гадуурхлаас ангид байна.
- 7.2. Багш, ажилтан Монгол Улсын хууль тогтоомж, МУИС-ийн дүрэм, МУИС-ийн багш, ажилтан, суралцагчийн ёс зүйн дүрэм, хүчин төгөлдөр мөрдөж буй бусад журмыг мөрдөж ажиллана.
- 7.3. Багш, ажилтан хууль тогтоомжийн дагуу тухайн ажлын байрны тодорхойлолт, ажлын шаардлагад заасан ажил үүргийг ректор буюу түүний эрх олгосон этгээдтэй байгуулсан хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр гүйцэтгэнэ.
- 7.4. МУИС багш, ажилтныг хөгжүүлэх хөтөлбөр боловсруулан үйл ажиллагааныхаа төлөвлөгөөнд тусгаж тогтмол хэрэгжүүлнэ.
- 7.5. Мэргэжлийн онцлогоос хамааруулан профессор багшийг судалгааны ба сургалтын чиглэлээр ажиллуулж болох ба уг асуудлыг журмаар зохицуулна.
- 7.6. МУИС-д олон жил үр бүтээлтэй ажилласан эрдэмтэн багшийн эрдэм мэдлэгийг нь өвлүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ. Ахмад багш нарыг ажиллуулах асуудлыг журмаар зохицуулна.
- 7.7. Багш, эрдэм шинжилгээ, сургалт, захиргаа, үйлчилгээний нэгжийн ажилтны үйл ажиллагааг үнэлэх аттестатчилыг журмаар зохицуулна.
- 7.8. МУИС-ийн багш тухайн салбараар мэргэшсэн, тодорхой чиглэлээр судалгааны ажил гүйцэтгэдэг, магистр, түүнээс дээш зэрэгтэй байна. Ахисан түвшний сургалтад оролцох багш докторын зэрэгтэй байна. Багш, ажилтны сул орон тоог нээлттэй зарлаж, сонгон шалгаруулж ажилд томилно.

- 7.9. Багшийн албан тушаал, цол, мэргэжлийн үнэлэмжийг сургалт, судалгаа, нийгмийн үйлчилгээний үйл ажиллагааны үзүүлэлтээр тодорхойлно.
- 7.10. МУИС-ийн харьяа эрдэм шинжилгээний хүрээлэн, төв нь өндөр түвшний мэдлэг чадвар бүхий судлаачдад нээлттэй байх ба үндсэн болон гэрээт эрдэм шинжилгээний ажилтнаас бүрдэнэ.
- 7.11. МУИС-ийн багш Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид заасан болон дараах эрхийг эдэлнэ:
- 7.11.1. Эрдэм шинжилгээний бүтээлээ дотоод, гадаадын **шинжилгээний ухааны** хэвлэлд нийтлүүлэх;
 - 7.11.2. МУИС-ийн мэдээллийн болон материаллаг нөөцийг албан зориулалтаар ашиглах;
 - 7.11.3. Хамтын хөдөлмөрийн гэрээнд заасан зохих нөхцөл, журмын дагуу цалинтай чөлөө, бүтээлийн чөлөө авах, ажлаас түр чөлөөлөгдөх;
 - 7.11.4. МУИС-ийн дэмжлэгтэйгээр боловсрол, мэргэшлээ дээшлүүлэх;
 - 7.11.5. МУИС-ийн удирдах байгууллагад сонгогдох, сонгох;
 - 7.11.6. Дотоод, гадаадын мэргэжлийн байгууллагад элсэх, уригдан ажиллах;
 - 7.11.7. МУИС-ийн үйл ажиллагааны талаар санал дүгнэлтээ удирдлага, холбогдох байгууллагад тавих эрхтэй.
- 7.12. Багш холбогдох хууль тогтоомжид заасан болон дараах үүргийг хүлээнэ:
- 7.12.1. Ажлын байрны тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээнд заасан үүргээ биелүүлэх;
 - 7.12.2. Хамт ажиллагчид болон суралцагчидтай хүндэтгэлтэй, шударга, ёс зүйтэй хандах;
 - 7.12.3. МУИС-ийн сургалт, судалгааны хүч хөрөнгөөр бий болсон оюуны бүтээлийг бусдад зүй бусаар ашиглуулахгүй байх;
 - 7.12.4. МУИС-ийн нэр хүндэд сөргөөр нөлөөлөх мэдээллийг үндэслэлгүйгээр олон нийтэд түгээхгүй байх.
- 7.13. Ажилтны эрх үүргийг Монгол Улсын хөдөлмөрийн тухай хууль тогтоомж, МУИС-ийн дүрэм, журам, ажлын байрны тодорхойлолтоор тогтооно.

НАЙМ. МУИС-ийн суралцагч

- 8.1. МУИС нь Монгол Улсын болон гадаадын иргэнийг яс үндэс, угсаа гарал, нас, хүйс, шашин шүтлэг, нийгмийн байдлыг нь харгалзахгүйгээр элсэн суралцах тэгш боломжоор хангана.
- 8.2. Суралцагч Монгол Улсын Боловсролын тухай хууль тогтоомж, МУИС-ийн дүрэм, журмыг дагаж мөрдөнө.
- 8.3. Суралцагчдыг элсүүлэх, суралцуулах, төгсгөх асуудлыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон нийтлэг журмыг үндэслэн МУИС-ийн холбогдох журам болон ректорын тушаалаар шийдвэрлэнэ.
- 8.4. МУИС оюутныг хөгжүүлэх, оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.
- 8.5. Суралцагч Монгол Улсын хууль тогтоомжид заасан болон дараах эрхийг эдэлнэ:
- 8.5.1. МУИС-ийн материаллаг болон мэдээллийн нөөцийг сургалт, эрдэм шинжилгээний зориулалтаар ашиглах;
 - 8.5.2. Шинжлэх ухааны хөгжлийн орчин үеийн ололтоос суралцах;
 - 8.5.3. Шинжлэх ухааны мэдлэг эзэмших зорилгоор профессор, багш нараас зөвлөгөө авах, эрдэм шинжилгээний үйл ажиллагаанд оролцох;
 - 8.5.4. МУИС-ийн үйлчилгээний нэгжүүдээс зохих журам, нөхцөлийн дагуу үйлчилгээ авах;

- 8.5.5. Сургалтын чанарын талаар саналаа илэрхийлэх;
- 8.5.6. Хууль тогтоомж болон сургуулийн дүрэм, журмын дагуу сургуулийн удирдах байгууллагад сонгогдох, сонгох;
- 8.5.7. Хууль тогтоомжид нийцсэн бусад үйл ажиллагаа явуулах эрхтэй.
- 8.6. Суралцагч холбогдох хууль тогтоомжид заасан үүрэг хүлээхээс гадна:
- 8.6.1. Сургалтын хөтөлбөрт заасан бүх хэлбэрийн үйл ажиллагаанд тогтмол оролцох;
- 8.6.2. Сургалтад шаардагдах хичээлийн хэрэглэгдэхүүнээр өөрийгөө хангах;
8.6.3. Багш, ажилтан, бусад суралцагчдад хүндэтгэлтэй хандах;
- 8.6.4. МУИС-ийн дүрэм, журмыг баримтлах;
- 8.6.5. МУИС-ийн хүрээнд ёс зүй, эерэг зан үйлийг чандлан сахих, эрдмийн нэр хүндийг хүндэтгэх;
- 8.6.6. МУИС-ийн нэр хүндэд сөргөөр нөлөөлөхүйц илт худал мэдээлэл түгээхгүй байх.
- 8.7. МУИС-ийн дүрэм, журмыг зөрчсөн нь тогтоогдсон суралцагчийг сануулах, сургуулиас чөлөөлөхийг сануулах, сургуулиас чөлөөлөх арга хэмжээг бүрэлдэхүүн сургуулийн захирлын саналыг үндэслэн МУИС-ийн ректор шийдвэрлэнэ.

ЕС. Багш, ажилтан, суралцагчийн байгууллага

- 9.1. МУИС-ийн багш, ажилтан, суралцагчид, төгсөгчид, ахмадуудын эрх, ашиг сонирхлыг хамгаалах зорилготой, сайн дурын үндсэн дээр эвлэлдэн нэгдсэн байгууллага өөрийн удирдлагын зарчимд тулгуурлан ажиллаж болно.
- 9.2. Багш, ажилтан, суралцагч, төгсөгчдийн сайн дурын байгууллага нь гишүүнчлэлтэй байх ба тэдгээрийн үйл ажиллагааг журмаар зохицуулна.
- 9.3. Багш, ажилтан, суралцагч, төгсөгчдийн төлөөллөөс тус тус бүрдэнэ.
- 9.4. Багш, ажилтан, суралцагч, төгсөгчдийн байгууллагын ажиллах журам МУИС-ийн дүрэм, журам болон холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна.
- 9.5. Багш, ажилтан, суралцагч, төгсөгчдийн байгууллага нь МУИС-ийн бодлого, үйл ажиллагааг төлөөлөх хуулийн этгээд болохгүй.
- 9.6. МУИС нь хуулийн хүрээнд эдгээр байгууллагын үйл ажиллагааг дэмжиж, гэрээний үндсэн дээр хамтран ажиллаж болно.

АРАВ. МУИС-ийн санхүү, хөрөнгө оруулалт

- 10.1. МУИС-ийн стратеги төлөвлөгөөнд тусгагдсан урт хугацааны зорилго, зорилтын хүрээнд төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнах үйл ажиллагааг ил тод, хариуцлагатай байх зарчимд нийцүүлэн тогтвортой, иж бүрэн, үнэн зөв, санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлнэ.
- 10.2. МУИС-ийн төсөв дараах эх үүсвэрээс бүрдэнэ.
- 10.2.1. Улсын төсвийн санхүүжилт, хөрөнгө оруулалт;
- 10.2.2. Сургалтын төлбөр;
- 10.2.3. Эрдэм шинжилгээний төсөл, гэрээт болон захиалгат судалгааны ажлын санхүүжилт;
- 10.2.4. Аж ахуйн үйл ажиллагааны нэмэлт орлого;
- 10.2.5. Зохих журмын дагуу аж ахуйн нэгж, байгууллага, иргэд, төгсөгчдөөс өгсөн хандив тусламж;
- 10.2.6. Шинжлэх ухааны паркийн орлого;
- 10.2.7. Лицензийн болон патентын төлбөр;
- 10.2.8. Хадгаламжийн болон харилцах дансны үлдэгдлийн хүү;

- 10.2.9. Түрээсийн төлбөр;
- 10.2.10. Эндаумент сангийн орлого;
- 10.2.11. Хуулиар хүлээн зөвшөөрөгдсөн сургууль хөгжүүлэх сан;
- 10.2.12. Хуульд нийцсэн санхүүгийн бусад эх үүсвэр.
- 10.3. МУИС-ийн эдийн засаг, санхүүгийн өдөр тутмын үйл ажиллагааг төсвийн шууд захирагч, асуудал эрхэлсэн проректор, бүрэлдэхүүн, салбар сургуулийн захирал, бүртгэл санхүүгийн ажилтнууд хариуцан гүйцэтгэнэ.
- 10.4. Сургуулийн хөрөнгө, санхүүгийн нөөцийг төсвийн дагуу хуваарилж, зарцуулах бөгөөд төсвийн шууд захирагч удирдах зөвлөлөөс баталсан төсвийг захиран зарцуулна.
- 10.5. Төсвийн шууд захирагч төсвийн зарим хэсгийг захиран зарцуулах эрх мэдлээ гэрээний үндсэн дээр проректор, бүрэлдэхүүн, салбар сургуулийн захиралд шилжүүлж болно.
- 10.6. Төсвийн шууд захирагч байгууллагын хөгжлийн төлөвлөгөө, инфляцын түвшин, төгрөгийн худалдан авах чадварын өөрчлөлт зэрэгт үндэслэн сургалт, үйлчилгээний төлбөрийг жил бүр тооцож, Удирдах зөвлөлд танилцуулна.
- 10.7. Сургалтын төлбөр болон бусад төлбөр хураамжийг шинэчлэн тогтоох ажлыг батлагдсан аргачлалын дагуу гүйцэтгэнэ.
- 10.8. МУИС-ийн болон бүрэлдэхүүн, салбар сургуулийн төсвийн төсөл, төсөв, төсвийн гүйцэтгэл, төсөвт орсон нэмэлт өөрчлөлт, санхүүгийн тайлан, түүнд хийсэн эдийн засгийн шинжилгээ, аудитын дүгнэлт, тендерийн баримт бичиг, шалгуур үзүүлэлт, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан үндэслэл, худалдан авах үйл ажиллагааны тайланг хуульд заасан хугацаанд сургуулийн цахим хуудсанд байрлуулна.
- 10.9. Хуульд заасан хугацаанд санхүүгийн болон бусад үйл ажиллагаандаа хөндлөнгийн аудитыг эрх бүхий байгууллагаар хийлгэж, ур дүнг Удирдах зөвлөл болон олон нийтэд ил тод мэдээлнэ.
